ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 II

# ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ГАРЧИГ


| | |
|---|---|
| | Ерөнхий тэмдэглэл |
| | Үндсэн үзүүлэлтүүд |
| I. | Хөдөлмөр |
| II. | Нийгмийн даатгал, халамж |
| III. | Эрүүл мэнд |
| IV. | Гэмт хэрэг |
| V. | Мөнгө, банк, зээл |
| VI. | Төсөв, санхүү |
| VII. | Хэрэглээний үнийн индекс |
| VIII. | Хөдөө аж ахуй |
| IX. | Аж үйлдвэр |
| X. | Байгаль орчин |

**I.** *Саруудыг ром тоогоор тэмдэглэв.*

- Сар: I, II, III, IV, V … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI … г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

**II.** *Дараах тэмдэглэгээг ашиглав.*

- … мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- # тухайн сар

**III.** *Хэмжих нэгжийн тэмдэглэгээ*

- мянга =1000
- сая =10
- тэрбум =10
- их наяд =$10^{12}$
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- м2 метр квадрат
- дм2 дециметр квадрат
- км2 километр квадрат
- м3 метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- Вт ватт
- кВт цкиловатт цаг
- калкалори ккалкилокалори
- Гкал гигакалори(=109 калори)
- мкг/$м^3$ микрограмм метр куб
- Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

ХЯНАСАН:

| | |
|---|---|
| Х.Өлзийсүрэн | Хэлтсийн дарга |

БЭЛТГЭН БОЛОВСРУУЛСАН:

| | |
|---|---|
| Б.Цэрэндорж | Аж үйлдвэр, Бизнес регистрийн сан хариуцсан Ахлах мэргэжилтэн |
| Б.Мөнхчимэг | Хүн ам, нийгмийн салбар, барилгын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн |
| У.Батчимэг | Хөдөө, аж ахуйн салбар хариуцсан мэргэжилтэн |

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Нутгийн удирдлагын ордон, 216 тоот

Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103

Утас: 70522749, 70520008

Цахим хуудас: www.dornogovi.nso.mn

Цахим шуудан: dornogovi@nso.mn

| Үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II |
|---|---|---|---|---|
| Ажил хайгч иргэн | хүн | 102 | 129 | 106 |
| Ажилд зуучилсан иргэн | хүн | 48 | 10 | 28 |
| Шинэ ажлын байранд орсон иргэн | хүн | 57 | 90 | 19 |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | сая төгрөг | 11 391.6 | 11 900.0 | 16 941.1 |
| Нийгмийн даатгалын сангийн зарлага | сая төгрөг | 18 572.9 | 22 187.2 | 23 514.2 |
| Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ | сая төгрөг | 14 380.6 | 20 183.5 | 20 946.9 |
| Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт | сая төгрөг | 8 156.6 | 9 172.7 | 9 568.3 |
| Хамрагдсан хүн | тоо | 42 486 | 41 595 | 41 649 |
| Төрөлт | хүн | 175 | 147 | 141 |
| Нас баралт | хүн | 52 | 47 | 56 |
| Эхийн эндэгдэл | хүн | - | - | - |
| Нялхсын эндэгдэл | хүн | - | 2 | 1 |
| Халдварт өвчнөөр өвчлөгчид | хүн | 188 | 148 | 158 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | тоо | 182 | 222 | 144 |
| Гэмт хэргийн улмаас нас барсан хүн | хүн | 17 | 6 | 6 |
| Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ | сая төгрөг | 1 188.8 | 1 195.7 | 2 335.2 |
| Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт | сая төгрөг | 20.3 | 109.1 | 397.1 |
| Банкны салбар нэгж | тоо | 57 | 56 | 55 |
| Зээлийн үлдэгдэл | сая төгрөг | 422 288.1 | 581 004.4 | 637 674.0 |
| Хадгаламжийн үлдэгдэл | сая төгрөг | 212 855.3 | 250 268.5 | 261 327.1 |
| Орон нутгийн төсвийн орлого | сая төгрөг | 16 008.2 | 14 858.2 | 15 919.3 |
| Орон нутгийн төсвийн зарлага | сая төгрөг | 9 279.3 | 12 314.9 | 24 149.0 |
| Хэрэглээний үнийн индекс (өмнөх сартай харьцуулсан) | хувь | 2.1 | 1.3 | 0.9 |
| Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулсан) | хувь | 8.9 | 8.0 | 7.2 |
| Зүй бусаар хорогдсон мал | толгой | 337 480 | 144 | 132 |
| Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт | сая төгрөг | 56 281.7 | 44 997.1 | 49 629.5 |
| Аж үйлдвэрийн салбарын борлуулалт | сая төгрөг | 147 324.3 | 47 979.9 | 99 582.5 |

# ХӨДӨЛМӨР

I-II/2026 Тархаасан: 2026 оны 03 дугаар сарын 16

## Ажил хайгч иргэдийн тоо 1 дүгээр сард 140 болжээ.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2026 оны 2 дугаар сарын мэдээгээр ажил хайгч иргэдийн тоо 140 болсны 74 (52.9%) эмэгтэйчүүд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажил хайгч иргэд 10 хүнээр буюу 6.7 хувиар буурчээ.

**ХҮСНЭГТ 1.1** **АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨН, жил бүрийн 2 дугаар сард**

| Үзүүлэлт | 2024 II | 2025 II | 2026 II | 2026 II / 2025 II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | Хувь |
| Хүн | | | | | |
| Ажил хайгч иргэн /сарын эхэнд/ | 160 | 150 | 140 | -10 | -6.7 |
| Үүнээс: эмэгтэй | 100 | 73 | 74 | 1 | 1.4 |
| Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн | 21 | 24 | 54 | 30 | 125.0 |
| Үүнээс: эмэгтэй | 4 | 10 | 22 | 12 | 120.0 |
| Тайлант хугацаанд хасагдсан иргэн | 79 | 45 | 88 | 43 | 95.6 |
| Үүнээс: эмэгтэй | 43 | 31 | 44 | 13 | 41.9 |
| Ажил хайгч иргэн /сарын эцэст/ | 102 | 129 | 106 | -23 | -17.8 |
| Үүнээс: эмэгтэй | 61 | 52 | 52 | - | 0.0 |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Тайлант сард нэмэгдсэн ажил хайгч иргэдийн 20 (50.0%) иргэн бусад, 1 (25.0%) одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй, 1 (25.0%) өөрийн хүсэлтээр ажлаас гарсан шалтгаанаар бүртгүүлжээ.

**ЗУРАГ 1.1** **АЖИЛ ХАЙЖ БАЙГАА ИРГЭД, нэмэгдсэн шалтгаанаар, 2 дугаар сард**



Ажил хайгч иргэдийн боловсролын түвшинг харахад 36 (34.0%) нь суурь, 32 (30.2%) бүрэн дунд, 15 (14.2%) дипломын болон бакалаврын дээд, 11 (10.4%) техник болон мэргэжлийн, 6 (5.7%) тусгай мэргэжлийн дунд, 3 (2.8%) бага, 2 (1.9%) боловсролгүй, 1 (0.9%) магистр, доктор, иргэд байна.

**ХҮСНЭГТ 1.2** **АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, боловсролын түвшингээр, жил бүрийн 2 дугаар сард**

| Боловсролын түвшингээр | 2024 II | 2025 II | 2026 II | 2026 II<br>2025 II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | Хувь |
| | Хүн | | | | |
| **Нийт** | **102** | **129** | **106** | **-23** | **-17.8** |
| Үүнээс: Эмэгтэй | 61 | 52 | 52 | - | 0.0 |
| Магистр, доктор | - | 3 | 1 | -2 | 0.0 |
| Дипломын болон бакалаврын дээд | 26 | 21 | 15 | -6 | -28.6 |
| Тусгай мэргэжлийн дунд | 7 | 10 | 6 | -4 | -40.0 |
| Техник болон мэргэжлийн | 7 | 11 | 11 | - | 0.0 |
| Бүрэн дунд | 45 | 36 | 32 | -4 | -11.1 |
| Суурь | 9 | 18 | 36 | 18 | 100.0 |
| Бага | 7 | 9 | 3 | -6 | -66.7 |
| Боловсролгүй | 1 | 21 | 2 | -19 | 0.0 |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Оны эхний 2 дугаар сард 28 иргэн ажилд зуучлагдсан байна. Өмнөх оны мөн үеэс ажилд зуучилсан иргэдийн тоо 10 (55.6%)-аар өсжээ.

**ЗУРАГ 1.2** **АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, 2 дугаар сард**




Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Хөдөлмөрийн хэлтсийн мэдээллээр ажлын байрны захиалга 35 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 38.8 хувиар буурчээ.

Шинэ ажлын байранд орсон иргэдийн тоо 90 болж, өмнөх оны мөн үеэс 33 (57.9%)-оор өссөн байна. Ажлын байрны шинж чанараар нь авч үзэхэд байнгын ажлын байраар хангагджээ.

## ХҮСНЭГТ 1.3 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, шинж чанараар, 2 дугаар сард

| Салбарын ангилал | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | | Бүгдээс:Ажлын байрны шинж, чанараар | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бүгд | Эмэгтэй | Байнга | Улирал | Түр |
| | | Хүн | | | | | |
| **Бүгд** | 57 | 90 | 19 | 10 | 10 | - | - |
| Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 4 | 11 | - | - | - | - | - |
| Уул уурхай, олборлолт | - | 2 | 1 | - | - | - | - |
| Боловсруулах үйлдвэрлэл | 21 | 22 | 5 | 2 | 2 | - | - |
| Цахилгаан, хий, уур агааржуулалт | - | - | - | - | - | - | - |
| Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | - | - | - | - | - | - | - |
| Барилга | 19 | 20 | - | - | - | - | - |
| Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ | 3 | 7 | - | - | - | - | - |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 2 | 10 | - | - | - | - | - |
| Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | - | - | - | - | - | - | - |
| Мэдээлэл холбоо | - | 1 | - | - | - | - | - |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | - | - | - | - | - | - | - |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | - | 1 | - | - | - | - | - |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | - | 1 | - | - | - | - | - |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал | - | 8 | 4 | 2 | 2 | - | - |
| Боловсрол | 4 | 3 | 1 | 1 | 1 | - | - |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 1 | 2 | 7 | 4 | 4 | - | - |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | - | - | 1 | 1 | 1 | - | - |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 3 | 1 | - | - | - | - | - |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | - | - | - | - | - | - | - |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | - | 1 | - | - | - | - | - |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

## Ойлголт тодорхойлолт

**Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн**

Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хөдөлгөөнийг ойлгоно.

**Ажил хайгч иргэн:**

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

**Эх үүсвэр:**

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

**Мэдээлэл авах холбоос:**

https://dornogovi.nso.mn/

**Дараагийн мэдээ тархаах хуваарь**

2026 оны 4 дүгээр сарын 15

Дорноговь аймгийн статистикийн хэлтсийн дарга Х. Өлзийсүрэн
Утас : 70520008

Хүн ам, нийгмийн салбар, барилгын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхчимэг
Утас: 70522749

# НИЙГМИЙН ДААТГАЛ

I-II /2026 Тархаасан: 2026 оны 03 дугаар сарын 15

## Тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар нэмэгджээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2 дугаар сарын байдлаар 16941.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5041.1 (42.4%) сая төгрөгөөр өссөн бөгөөд төлөвлөгөөнөөс 16.5 хувиар давуулан биелсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 5041.1 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сан 4291.6 сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сан 478.0 сая төгрөгөөр, ҮОМШӨ*-ны даатгал 137.7 сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сан 133.8 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

**ХҮСНЭГТ 2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, төрлөөр**

| | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | | 2026 I-II 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өөрчлөлт | Хувь |
| | сая төгрөг | | | | | |
| **Нийт дүн** | **11 391.6** | **11 900.0** | **14 541.5** | **16 941.1** | **5 041.1** | **42.4** |
| Тэтгэврийн даатгал | 9 132.6 | 9 453.2 | 12 029.4 | 13 744.8 | 4 291.6 | 45.4 |
| Тэтгэмжийн даатгал | 963.3 | 985.7 | 1 260.8 | 1 463.7 | 478.0 | 48.5 |
| ҮОМШӨ*-ны даатгал | 1 099.2 | 1 064.6 | 797.7 | 1 202.3 | 137.7 | 12.9 |
| Ажилгүйдлийн даатгал | 196.5 | 396.5 | 453.6 | 530.3 | 133.8 | 33.7 |

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн зарлага 23514.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1327.0 (6.0%) сая төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 20721.9 (88.1%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1218.2 (5.2%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 1316.4 (5.6%) сая төгрөг, ҮОМШӨ*-ны даатгалын сангаас 257.7 (1.1%) сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

**ХҮСНЭГТ 2.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр**

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | | 2026 I-II 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өөрчлөлт | Хувь |
| | сая төгрөг | | | | | |
| **Нийт дүн** | **18 572.9** | **22 187.2** | **23 575.7** | **23 514.2** | **1 327.0** | **6.0** |
| Тэтгэврийн даатгал | 16 981.4 | 19 988.9 | 20 522.4 | 20 721.9 | 733.0 | 3.7 |
| Тэтгэмжийн даатгал | 605.3 | 1 150.6 | 1 435.9 | 1 218.2 | 67.6 | 5.9 |
| ҮОМШӨ*-ны даатгал | 555.8 | 241.5 | 243.9 | 257.7 | 16.2 | 6.7 |
| Ажилгүйдлийн даатгал | 430.4 | 806.2 | 1 373.5 | 1 316.4 | 510.2 | 63.3 |

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

**ЗУРАГ 2.1** **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2026 оны 2 дугаар сарын байдлаар**




Нийгмийн даатгалын сангийн нийт орлогод тэтгэврийн даатгалын сан 81.1 хувийг, тэтгэмжийн даатгалын сан 8.6 хувийг, ҮОМШӨ*-ны даатгалын сан 7.1 хувийг, ажилгүйдлийн даатгалын сан 3.1 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ҮОМШӨ*-ний даатгалын сангийн эзлэх хувь 1.8 нэгж хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 0.2 нэгж хувиар тус тус буурсан бол тэтгэврийн даатгалын сан 1.7 нэгж хувиар, тэтгэмжийн даатгалын сан 0.4 нэгж хувиар тус тус нэмэгджээ.

Нийгмийн даатгалд даатгуулагчид 25651 болж, өмнөх оны мөн үеэс 200 (0.8%)-аар буурчээ. Нийт даатгуулагчдын 22356 нь албан журмаар, 3295 нь сайн дураар даатгуулсан иргэд байна. Албан журмаар даатгуулагчдын 14759 (66.0%) нь аж нэгж байгууллагын ажилчид бол 7597 (34.0%) нь төсөвт байгууллагын ажилчид байна.

**ХҮСНЭГТ 2.3** **НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, төрлөөр**

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II Өөрчлөлт | 2026 I-II / 2025 I-II Хувь |
|---|---|---|---|---|---|
| Хүн | | | | | |
| **Дүн** | **25 358** | **25 851** | **25 651** | **- 200** | **-0.8** |
| Албан журмаар даатгуулагчид | 22 017 | 22 593 | 22 356 | - 237 | -1.0 |
| Аж ахуйн нэгж байгууллага | 12 805 | 12 997 | 14 759 | 1 762 | 13.6 |
| Төсөвт байгууллага | 9 212 | 9 596 | 7 597 | -1 999 | -20.8 |
| Сайн дураар даатгуулагчид | 3 341 | 3 258 | 3 295 | 37 | 1.1 |

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

**ЗУРАГ 2.2** **НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, төрлөөр, дүнд эзлэх хувиар**



Нийт даатгуулагчдын дунд 87.2 хувийг албан журмын, 12.8 хувийг сайн дурын даатгуулагчид эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс албан журмын даатгуулагчид 0.2 нэгж хувиар буурч, сайн дурын даатгуулагчид 0.2 нэгж хувиар нэмэгдсэн .

Тэтгэвэр авагчид 10943 хүн, 20946.9 сая төгрөгийн тэтгэвэр авсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэвэр авагчдын тоо 360 (3.4%)-аар, олгосон тэтгэвэр 763.4 (3.8%) сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

**ХҮСНЭГТ 2.4** **ТЭТГЭВЭР АВАГЧИД БОЛОН ОЛГОСОН ТЭТГЭВЭР, төрлөөр**

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | Хувь |
| | | Хүн | | | |
| **Нийт дүн** | **10 072** | **10 583** | **10 943** | **360** | **3.4** |
| Өндөр насны тэтгэвэр | 7 704 | 8 059 | 8 312 | 253 | 3.1 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэд | 1 243 | 1 353 | 1 397 | 44 | 3.3 |
| Тэжээгчээ алдсаны тэтгэмж | 458 | 472 | 507 | 35 | 7.4 |
| Цэргийн тэтгэвэр | 551 | 581 | 617 | 36 | 6.2 |
| ҮОМШӨ*-ний | 116 | 118 | 110 | -8 | -6.8 |
| | | Олгосон тэтгэвэр, сая төгрөгөөр | | | |
| **Нийт дүн** | **14 380.6** | **20 183.5** | **20 946.9** | **763.4** | **3.8** |
| Өндөр насны тэтгэвэр | 10 976.6 | 16 001.6 | 15 974.3 | - 27.3 | -0.2 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэд | 1 345.2 | 1 638.6 | 2 003.3 | 364.8 | 22.3 |
| Тэжээгчээ алдсаны тэтгэмж | 489.8 | 628.4 | 769.6 | 141.2 | 22.5 |
| Цэргийн тэтгэвэр | 1 454.2 | 1 718.1 | 1 973.2 | 255.1 | 14.8 |
| ҮОМШӨ*-ний | 114.8 | 196.9 | 226.5 | 29.6 | 15.0 |

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

Нийт тэтгэвэр авагчдын 8312 (76.0%) нь өндөр насны тэтгэвэр, 1397 (12.8%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, 617 (5.6%) нь цэргийн тэтгэвэр, 507 (4.6%) нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 110 (1.0%) нь ҮОМШӨ*-ний тэтгэвэр байна.

**ЗУРАГ 2.3** **ОЛГОСОН ТЭТГЭВЭР, дунд эзлэх хувиар, 2026 оны 2 дугаар сарын байдлаар**




Олгосон тэтгэвэр тэтгэмжийн 76.2 хувийг нь өндөр насны тэтгэвэр, 9.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, 9.4 хувийг цэргийн тэтгэвэр, 3.7 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэмж, 1.1 хувийг ҮОМШӨ*-ний тэтгэвэр тус тус эзэлж байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 41649 иргэнд 9568.3 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан

иргэдийн тоо 54 (0.1%)-өөр буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмж 395.6 (4.3 %) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**ЗУРАГ 2.4 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ**




Нийгмийн халамжид хамрагдсан хүний 38693 (92.9%) иргэн нь бусад халамжид, 1312 (3.2%) иргэн нь халамжийн тэтгэвэрт, 1220 (2.9%) иргэн нь халамжийн тэтгэмжид, 422 (1.0%) иргэн нь амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид тус тус хамрагджээ.

**ХҮСНЭГТ 2.5 ХАЛАМЖИД ХАМРАГДСАН ХҮН, төрлөөр**

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | Хувь |
| Хүн | | | | | |
| **Нийт дүн** | **42 486** | **41 595** | **41 649** | **54** | **0.1** |
| Халамжийн тэтгэвэр | 1 239 | 1 212 | 1 312 | 100 | 8.3 |
| Халамжийн тэтгэмж | 1 141 | 1 121 | 1 220 | 99 | 8.8 |
| Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн | 342 | 318 | 422 | 104 | 32.7 |
| Бусад халамжийн дүн | 39 760 | 38 943 | 38 693 | - 250 | -0.6 |
| Нийгмийн халамжийн сан | 4 | 1 | 2 | 1 | 2.0² |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Халамжийн сангаас 7261.7 (75.9%) сая төгрөгийг бусад төрлийн халамжид, 1192.4 (12.5) сая төгрөгийг халамжийн тэтгэвэрт, 830.8 (8.7) сая төгрөгийг халамжийн тэтгэмжид, 281.0 (2.9%) сая төгрөгийг амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид, 2.4 сая төгрөгийг нийгмийн халамжийн санд тус тус зарцуулсан байна.

**ЗУРАГ 2.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2026 оны 2 дугаар сарын байдлаар**



Бусад төрлийн халамжийн дунд10 төрлийн халамжийн тэтгэмжийг тооцсон бөгөөд 72.6 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж эзэлж байна. Аймгийн хэмжээнд 26438 хүүхдэд 5273.6 сая төгрөгийг олгожээ.

**ХҮСНЭГТ 2.6 БУСАД ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр**

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II хувь | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүн | | | | сая төгрөг | | | |
| **Бүгд** | **39 760** | **38 943** | **38 693** | **-0.6** | **6 585.9** | **7 269.4** | **7 261.7** | **-0.1** |
| Жирэмсэн эхийн тэтгэмж | 374 | 320 | 410 | 28.1 | 30.8 | 26.4 | 27.7 | 4.9 |
| ХБИ-д үзүүлэх тусламж | 75 | 71 | 79 | 11.3 | 9.9 | 14.6 | 18.9 | 29.5 |
| Хүнс тэжээл | 628 | 560 | 117 | -79.1 | 14.4 | 10.6 | 3.3 | -68.9 |
| Алдар цолтой ахмад | | | | | | | | |
| Алдарт эхийн одонгийн тусламж | 5 454 | 5 606 | 5 722 | | 686.7 | 1 388.8 | 1 416.8 | |
| Насны хишиг | 3 260 | 3 589 | 3 802 | | 258.2 | 279.1 | 301.4 | |
| Цалинтай ээж | 2 392 | 2 215 | 2 023 | -8.7 | 243.3 | 219.3 | 193.0 | -12.0 |
| Өрх толгойлсон эх/эцэгт | 5 | 8 | 10 | | .7 | 1.6 | 3.5 | |
| Ихэр хүүхэдтэй өрх | 1 | 3 | 4 | 33.3 | 2.0 | 6.0 | 8.0 | 33.3 |
| Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт | 997 | 30 | 88 | 193.3 | 26.0 | 16.9 | 15.5 | -8.3 |
| Хүүхдийн мөнгөн тэтгэмж | 26 574 | 26 541 | 26 438 | -0.4 | 5 313.9 | 5 306.1 | 5 273.6 | -0.6 |

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Бусад халамжийн сангийн зарцуулалтаас харахад 1416.8 сая төгрөгийг алдарт эхийн одонгийн тусламжид, 301.4 сая төгрөгийг насны хишигт, 193.0 сая төгрөгийг цалинтай ээж хөтөлбөрийн тэтгэмжид, 27.7 сая төгрөгийг жирэмсэн эхийн тэтгэмжид, 18.9 сая төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламжид, 15.5 сая төгрөгийг ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөд, 8.0 сая төгрөгийг ихэр хүүхэдтэй өрхөд, 3.5 сая төгрөгийг өрх толгойлсон эцэг/эхэд, тусламжид, 3.3 сая төгрөгийг хүнс тэжээлийн дэмжлэгт тус тус зарцуулсан байна.

## Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эх үүсвэр:

Нийгмийн даатгалын хэлтэс
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос:

https://dornogovi.nso.mn/

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2026 оны 04 дугаар сарын 15

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн дарга Х.Өлзийсүрэн Утас: 70520008

Аж үйлдвэрийн салбарын мэдээ, бизнес регистрийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Б:Цэрэндорж Утас: 70522749

# ЭРҮҮЛ МЭНД

I-II/2026 Тархаасан: 2026 оны 3 дугаар сарын 16

## Оны эхний 2 дугаар сард 142 хүүхэд шинээр мэндэлжээ.

Эрүүл мэндийн газраас ирүүлсэн мэдээллээр 2026 оны эхний 2 дугаар сарын байдлаар амбулаторийн үзлэгт 76.3 мянган хүн хамрагдаж, 2.5 мянган хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад амбулаторийн үзлэг 5.2 (7.3%) мянган хүнээр, хэвтэн эмчлүүлсэн хүн 0.7 (21.9%) мянган хүнээр тус тус буурсан байна.

**ХҮСНЭГТ 3.1** **ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ**

| Үндсэн үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | хувь |
| Мянган хүн | | | | | |
| Амбулаторын үзлэг | 68.4 | 71.1 | 76.3 | 5.2 | 7.3 |
| Эмчлүүлсэн хүн | 3.5 | 3.2 | 2.5 | -0.7 | -21.9 |
| Ор хоног | 25.4 | 22.3 | 17.2 | -5.1 | -22.9 |
| Урьдчилан сэргийлэх тарилга | 1.7 | 1.5 | 1.2 | -0.3 | -20.0 |
| Түргэн тусламжийн дуудлага | 3.2 | 2.8 | 2.6 | -0.2 | -7.1 |
| Үүнээс: алсын дуудлага | 0.4 | 0.4 | 0.2 | -0.2 | -50.0 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

Мөн урьдчилан сэргийлэх тарилгад 1.2 мянган хүн хамрагдаж, 2.6 мянган удаа түргэн тусламжийн дуудлага гарсаны 7.7 хувь буюу 0.2 мянга нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн дуудлага 0.2 (7.1%) мянган хүнээр, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүн 1.2 (20.0%) мянган хүнээр тус тус буурсан байна.

**ЗУРАГ 3.1** **ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛ**




Осол гэмтлийн өвчлөл 469 бүртгэгдэж, үүний улмаас 10 хүн нас барсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад осол гэмтлийн өвчлөл 15 (3.3%)-аар өссөн байна.

Аймгийн хэмжээнд оны эхний 2 дугаар сарын байдлаар 213 эх жирэмсний хяналтанд орсны 96.2 хувь буюу 205 эх эхний 3 сартайдаа хяналтанд хамрагдсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад жирэмсний хяналтанд орсон нийт эхчүүд 43 (16.8%)-аар, эхний 3 сартайдаа хяналтанд орсон эхчүүд 24 (10.5%)-аар тус тус буурсан байна.

**ХҮСНЭГТ 3.2 АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД**

| Үндсэн үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | хувь |
| | Хүн | | | | |
| Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх | 232 | 256 | 213 | - 43 | -16.8 |
| Үүнээс: эхний 3 сартайд | 208 | 229 | 205 | - 24 | -10.5 |
| Амаржсан эх | 175 | 147 | 141 | - 6 | -4.1 |
| Үүнээс: нас баралт | ... | ... | ... | ... | ... |
| Амьд төрсөн хүүхэд | 175 | 148 | 142 | - 6 | -4.1 |
| Нялхсын эндэгдэл /0-1 хүртэлх нас/ | ... | 2 | 1 | - 1 | -50.0 |
| Эндсэн хүүхэд /1-5 хүртэлх нас/ | 1 | ... | ... | ... | ... |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

Он гарсаар эхний 2 дугаар сард 141 эх амаржиж, 142 хүүхэд шинээр мэндэлжээ. Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 6 (4.1%)-ээр, төрсөн хүүхдийн тоо 6 (4.1%)-аар тус тус буурсан байна. Нялхсын эндэгдэл /0-1 хүртлэх нас/ 1 бүртгэгдсэн байна.

**ЗУРАГ 3.2 НАС БАРАЛТ**




Нас барсан хүний тоо 2026 оны 2 дугаар сарын байдлаар 56 болж, өмнөх оны мөн үеэс 9 (19.1%)-аар нэмэгдсэн байна. Нас барсан иргэдийг өвчний шалтгаанаар нь авч үзэхэд 26.8 хувийг хавдрын өвчлөл, 26.8 хувийг цусны эргэлтийн тогтолцооны өвчин, 25.0 хувийг бусад төрлийн өвчлөл, 17.9 хувийг осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл, 3.6 хувийг амьсгалын тогтолцооны өвчин тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 3.3 НАС БАРАЛТ, өвчний шалтгаанаар, дүнд эзэлх хувиар**



## ЗУРАГ 3.4 ХҮН АМЫН ЦЭВЭР ӨСӨЛТ




Хүн амын төрөлт, нас баралтын зөрүүгээр илэрхийлэгддэг үзүүлэлтийг хүн амын цэвэр өсөлт гэнэ. 2026 оны 2 дугаар сарын байдлаар хүн амын цэвэр өсөлт 86 болсон нь өмнөх оны мөн үеэс 15 (14.9%)-өөр буурчээ.

## ЗУРАГ 3.5 ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, 1000 хүнд ногдохоор




Оны эхний 2 дугаар сард 1000 хүнд ногдох төрөлт 2.0, нас баралт 0.8 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.1 нэгж хувиар буурч, нас баралт 0.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Халдварт өвчний тоо 158 болж, өмнөх оны мөн үеэс 10 (6.8%)-аар өссөн байна. Өмнөх оны мөн үеэс халдварт өвчин 14.7 хувиар өсхөд салхин цэцэг 3 (7.0%)-аар, заг хүйтэн 2 (13.3%)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

## ХҮСНЭГТ 3.3 ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр

| Үндсэн үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | хувь |
| | Хүн | | | | |
| **Халдварт өвчин** | **188** | **148** | **158** | **10** | **6.8** |
| Вируст гепатит | ... | ... | ... | ... | ... |
| Сүрьеэ | 9 | 8 | 8 | | 0.0 |
| Тэмбүү | 9 | 10 | 5 | -5 | -50.0 |
| Заг хүйтэн | 25 | 29 | 29 | | 0.0 |
| Трихоминаиз | 6 | 3 | 5 | 2 | 66.7 |
| Цусан суулга | 7 | 3 | 5 | 2 | 66.7 |
| Салхин цэцэг | 117 | 83 | 90 | 7 | 8.4 |
| Бусад | 15 | 12 | 16 | 4 | 33.3 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн мэдээллээр оны эхний 2 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 3329.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1236.0 (59.0%) сая төгрөгөөр нэмэгдэж, эрүүл мэндийн сангийн тусламж үйлчилгээний зардал 2945.7 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4723.1 (61.6%) сая төгрөгөөр буурчээ.

**ЗУРАГ 3.6** **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**




Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний зардлыг төрлөөр нь авч үзэхэд лавлагаа шатлалын байгууллагын тусламж үйлчилгээний зардалд 4588.8 (70.7%) сая төгрөг, сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний зардалд 1056.1 (16.3%) сая төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний зардалд 315.2 (4.9%) сая төгрөгийг, хөнгөлөлттэй эмийн зардалд 525.9 (8.1%) сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**ХҮСНЭГТ 3.5** **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, зарцуулалтын төрлөөр**

| Үндсэн үзүүлэлт | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II<br>2025 I-II | |
|---|---|---|---|---|
| | | | Өөрчлөлт | хувь |
| Сая төгрөг | | | | |
| Дүн | 7 658.5 | 6 486.0 | -1 172.5 | -15.3 |
| Лавлагаа шатлалын байгууллагын тусламж үйлчилгээ | 6 186.0 | 4 588.8 | -1 597.2 | -25.8 |
| Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ | 871.6 | 1 056.1 | 184.5 | 21.2 |
| Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ | 121.1 | 315.2 | 194.1 | 160.3 |
| Хөнгөлөлттэй эмийн тусламж үйлчилгээ | 479.8 | 525.9 | 46.1 | 9.6 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын хэлтэс

**ЗУРАГ 3.6 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, дүнд эзлэх хувиар**




Эрүүл мэндийн даатгалд 63306 иргэн даатгуулсан байна. Нийт даатгуулагчийн 46365 (73.2%) иргэн нь шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд, 15351 (24.2%) иргэн нь шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд, 1590 (2.5%) иргэн нь шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрөлт: **Хүн төрөлхтний дунд явагдаж** буй нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.

Төрөлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Нас баралт: Хүн төрөлхтний дунд гарч буй нөхөн ужихүйн үзэгдлийн нэг. Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын хэв маяг, эрүүл ахуйн нөхцөл, өвчлөл нь нас баралтын түвшинд нөлөө үзүүлдэг учир энэ үзүүлэлтийг нас баралтын шалтгаанаар нь тодорхойлж болно.

Нас баралтын ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт: Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

Эх үүсвэр:
Эрүүл мэндийн газар

Мэдээлэл авах холбоос:
https://dornogovi.nso.mn/

Дараагийн мэдээ тархаах хуваарь:
2026 оны 04 дугаар сарын 15

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн дарга Х.Өлзийсүрэн
Утас : 70520008

Хүн ам, нийгмийн салбар, барилгын мэдээ тайлан хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхчимэг
Утас : 70522749

# ГЭМТ ХЭРЭГ

I-II/2026

Тархаасан: 2026 оны 3 дугаар сарын 16

## Гэмт хэргийн улмаас сард 6 хүн нас баржээ.

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 144 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 78 (35.1%)-аар буурчээ. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 58 буюу 40.3 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал бусад төрлийн гэмт хэрэг 7 (43.8%)-оор нэмэгдсэн. Харин хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 4 (66.7%)-иар, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 1 (50.0%)-иар, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 17 (43.6%)-аар, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 3 (42.9%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 16 (34.0%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын 1 (25.0%)-иар, тус тус буурсан. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг энэ онд бүртгэгдээгүй байна.

### ХҮСНЭГТ 4.1 ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | хувь |
| Хүн | | | | | |
| **Бүгд** | **182** | **222** | **144** | **-78** | **-35.1** |
| Хүний амьд явах эрхийн эсрэг | 7 | 7 | 4 | -3 | -42.9 |
| Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг | 4 | 4 | 3 | -1 | -25.0 |
| Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан | 40 | 47 | 31 | -16 | -34.0 |
| Өмчлөх эрхийн эсрэг | 88 | 91 | 58 | -33 | -36.3 |
| Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг | - | 9 | - | -9 | 0.0 |
| Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг | 1 | 1 | - | -1 | 0.0 |
| Хүрээлэн байгаа орчны эсрэг | 2 | 6 | 2 | -4 | -66.7 |
| Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг | 26 | 39 | 22 | -17 | -43.6 |
| Эрүүл мэндийн эсрэг | 1 | 2 | 1 | -1 | -50.0 |
| Бусад гэмт хэрэг | 13 | 16 | 23 | 7 | 43.8 |

Эх үүсвэр: Цагдаагийн газар

**ЗУРАГ 4.1** **ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, 2026 оны 2 дугаар сарын байдлаар**




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 22.9 хувь буюу 33 нь хүнд хэлбэрийн гэмт хэрэг бол үлдсэн 77.1 хувь буюу 111 нь хөнгөн хэлбэрийн гэмт хэрэг бүртгэгджээ.

**ЗУРАГ 4.2** **ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, эзлэх хувиар**




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 40.3 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 22.9 хувийг бусад төрлийн гэмт хэрэг, 21.5 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 15.3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад гэмт хэрэг 2.6 нэгж хувиар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 0.4 нэгж хувиар тус тус нэмэгдэж, харин хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2.3 нэгж хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 0.7 нэгж хувиар тус тус буурав.

**ЗУРАГ 4.3** **ГЭМТ ХЭРЭГ, сараар**



Гэмт хэргийн улмаас 2 дугаар сарын байдлаар 104 хүн хохирч, 41 хүн гэмтэж, 6 хүн нас барсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирсон хүн 80 (43.5%)-аар, гэмтсэн хүн 19 (31.7%)-өөр тус тус буурч, нас барсан хүн өмнө оны мөн үетэй адил байна..

**ХҮСНЭГТ 4.2 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХҮН**

| Үзүүлэлт | Хохирсон хүн | | Гэмтсэн хүн | | Нас барсан хүн | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2025 I-II | 2026 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2025 I-II | 2026 I-II |
| Нийт | 184 | 104 | 60 | 41 | 6 | 6 |
| 0-17 насны | 13 | 3 | 7 | 1 | 1 | 0 |
| 18-34 насны | 52 | 27 | 16 | 11 | 1 | 1 |
| 35-54 насны | 97 | 56 | 33 | 25 | 4 | 4 |
| 55-аас дээш насны | 22 | 18 | 4 | 4 | 0 | 1 |

Эх үүсвэр: Цагдаагийн газар

Бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн газраар авч үзэхэд 59 (41.0%) нь бусад газарт, 41 (28.5%) нь гэр орон сууцандаа, 21 (14.6%) нь авто замд, 11 (7.6%) нь аж ахуйн нэгжид, 8 (5.6%) нь олон нийтийн газарт, 4 (2.8%) нь гудамж талбайд тус тус үйлдэгджээ.

**ХҮСНЭГТ 4.3 ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн газар**

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II<br>2025 I-II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | хувь |
| Бүгд | 182 | 222 | 144 | -78 | -35.1 |
| Гэр орон сууцанд | 35 | 48 | 41 | -7 | -14.6 |
| Гудамж талбайд | 13 | 24 | 4 | -20 | -83.3 |
| Олон нийтийн газарт | 14 | 12 | 8 | -4 | -33.3 |
| Аж ахуйн нэгжид | 15 | 6 | 11 | 5 | 83.3 |
| Авто замд | 25 | 38 | 21 | -17 | -44.7 |
| Бусад газарт | 80 | 94 | 59 | -35 | -37.2 |

Эх үүсвэр: Цагдаагийн газар

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж ахуйн нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 83.3 хувиар нэмэгдэж, гудамж талбайд үйлдсэн гэмт хэрэг 83.3 хувиар, авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 44.7 хувиар, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 37.2 хувиар, олон нийтийн газарт үйлдэгдсэн нь 33.3 хувиар, гэр орон сууцандаа үйлдсэн гэмт хэрэг 14.6 хувиар тус тус буурсан байна.

**ЗУРАГ 4.4 ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн цагаар, 2026 оны 2 дугаар сарын байдлаар**



Гэмт хэргийг үйлдэгдсэн цагаар авч үзэхэд 39.6 хувь нь 22.00-06.00 цагийн хооронд, 26.4 хувь нь 06.00-14.00 цагийн хооронд, 25.7 хувь нь 14.00-19.00 цагийн хооронд, 8.3 хувь нь 19.00-22.00 цагийн хооронд тус тус үйлдэгджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 06.00-14.00 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 2.9 нэгж хувиар, 19.00-22.00 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 2.9 нэгж хувиар, 14.00-19.00 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 3.6 нэгж хувиар тус тус буурсан бол 22.00-06.00 цагийн үйлдэгдсэн гэмт хэрэг 9.4 нэгж хувиар нэмэгдсэн.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 2335.2 сая төгрөгийн хохирол учирснаас 397.1 (17.0%) сая төгрөг нөхөн төлөгдсөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад учирсан хохирол 1139.5 (95.3%) сая төгрөгөөр, нөхөн төлүүлэлт 288.0 (3.6 дахин) сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

**ЗУРАГ 4.5 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, сая төгрөгөөр**




## ЗӨРЧИЛ

Аймгийн хэмжээнд 8584 зөрчил бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 236 (2.7%) зөрчлөөр буурчээ. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 8454 (98.5%) зөрчлийг торгууль шийтгэл оногдуулж, 31 (0.4%) зөрчлийг баривчилж шийдвэрлэжээ. Харин 99 зөрчил буюу 1.2 хувь нь шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

**ХҮСНЭГТ 4.4 БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, төрлөөр**

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-ii | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | хувь |
| Бүгд | 5 161 | 8 820 | 8 584 | - 236 | -2.7 |
| Торгууль шийтгэл оногдуулсан | 5 052 | 8 639 | 8 454 | - 185 | -2.1 |
| Баривчилсан | 49 | 40 | 31 | - 9 | -22.5 |
| Шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрчил | 60 | 141 | 99 | - 42 | -29.8 |

Эх үүсвэр: Цагдаагийн газар

**ЗУРАГ 4.6** **БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, үйлдэгдсэн цагаар, 2026 оны 2 дугаар сарын байдлаар**




Бүртгэгдсэн зөрчлийн 4205 (49.0%) нь 12.00-18.00 цагийн хооронд, 2219 (25.9%) нь 06.00-12.00 цагийн хооронд, 1996 (23.3%) нь 18.00-24.00 цагийн хооронд, 164 (1.9%) нь 24.00-06.00 цагийн хооронд тус тус үйлдэгджээ.
Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт гэмт хэргийн 12.00-18.00 цагийн хооронд үйлдэгдсэн нь 0.4 нэгж хувиар, 06.00-12.00 цагийн хооронд үйлдэгдсэн нь 1.4 нэгж хувиар тус тус нэмэгдэж, 18.00-24.00 цагийн хооронд үйлдэгдсэн нь 0.9 нэгж хувиар, 24.00-06.00 цагийн хооронд үйлдэгдсэн нь 0.9 нэгж хувиар тус тус буурчээ.

**ЗУРАГ 4.7** **ЗӨРЧИЛ, төрлөөр, дунд эзлэх хувиар**




Нийт бүртгэгдсэн зөрчлийн 8584 буюу 95.1 хувь нь бэлэн бус зөрчил бол 446 буюу 4.9 хувь нь хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчил байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хялбаршуулсан журмаар зөрчийн хэрэг нээн шалгасан зөрчлийн эзлэх хувь 2.0 нэж хувиар буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 446 буюу 4.9 хувь нь хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчил бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 208 (31.8%)-аар буурсан байна. Харин зөрчлийн төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зөрчил хамгийн өндөр буюу 194 (37.6%)-өөр буурсан байна.

**ХҮСНЭГТ 4.5** **ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЭЭН ШАЛГАСАН ЗӨРЧИЛ, төрлөөр**

| Үзүүлэлт | 2025 I-II | 2026 I-II | Зөрчлийн бүтэц | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2026 I-II 2025 I-II | 2025 I-II | 2026 I-II |
| | | | Өөрчлөлт | хувь | |
| Бүгд | 654 | 446 | -208 | 100.0 | 100.0 |
| Олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах | 2 | 2 | 0 | 0.3 | 0.4 |
| Танхайрах | 23 | 32 | 9 | 3.5 | 7.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хүний биед халдах | 17 | 15 | -2 | 2.6 | 3.4 |
| Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай | 49 | 44 | -5 | 7.5 | 9.9 |
| Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн | 2 | 3 | 1 | 0.3 | 0.7 |
| Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчсөн | 11 | 12 | 1 | 1.7 | 2.7 |
| Хүүхдийн эрхийг зөрчих | 5 | 4 | -1 | 0.8 | 0.9 |
| Эд хөрөнгө устгах, гэмтээх | 5 | 4 | -1 | 0.8 | 0.9 |
| Худалдаа, үйлчилгээний журам зөрчсөн | 1 | 1 | 0 | 0.2 | 0.2 |
| Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих | 516 | 322 | -194 | 78.9 | 72.2 |
| Авто замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах | 1 | 0 | -1 | 0.2 | 0.0 |
| Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд саад учруулах | 9 | 3 | -6 | 1.4 | 0.7 |
| Хуурамч дуудлага мэдээлэл өгөх | 2 | 1 | -1 | 0.3 | 0.2 |
| Мал махны үйлдвэрлэл, худалдаа эрхлэх журам зөрчсөн | 5 | 0 | -5 | 0.8 | 0.0 |

Эх үүсвэр: Цагдаагийн газар

Хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчлийг төрлөөр нь дунд эзлэх хувиар авч үзэхэд дийлэнх буюу 72.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зөрчил, 9.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зөрчил, 7.2 хувийг танхайрах зөрчил, 3.4 хувийг хүний биед халдах зөрчил, 2.7 хувийг архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зөрчил, 4.7 хувийг бусад төрлийн зөрчил эзэлж байна.

**ЗУРАГ 4.8** **ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЭЭН ШАЛГАСАН ЗӨРЧИЛ, дунд эзлэх хувиар, 2026 оны 2 дугаар сарын байдлаар**




Хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчлийн 347 (77.8%) нь шийдэгдэж, торгууль шийтгэл оногдуулсан бол үлдсэн 99 (22.2%) нь шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрчил байна.

Хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчлийг үйлдэгдсэн газраар авч үзэхэд 317 (71.1%) нь авто зам дээр, 71 (15.9%) нь гэр, орон сууцандаа, 20 (4.5%) нь гудамж талбайд, 17 (3.8%) нь олон нийтийн газарт, 11 (2.5%) нь аж ахуйн нэгж дээр, 5 (1.1%) нь төрийн бус байгууллагад, 5 (1.1%) нь бусад газарт тус тус үйлдэгдсэн зөрчлүүд байна.

## ХҮСНЭГТ 4.6 ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЭЭН ШАЛГАСАН ЗӨРЧИЛ, үйлдэгдсэн газраар

| Үзүүлэлт | 2024 I-II | 2025 I-II | 2026 I-II | 2026 I-II / 2025 I-II | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Өөрчлөлт | хувь |
| **Бүгд** | **542** | **654** | **446** | **-208** | **-31.8** |
| Авто замд | 371 | 515 | 317 | -198 | -38.4 |
| Гэр орон сууцанд | 76 | 76 | 71 | -5 | -6.6 |
| Гудамж талбайд | 32 | 33 | 20 | -13 | -39.4 |
| Бусад газар | 18 | 6 | 5 | -1 | -16.7 |
| Олон нийтийн газар | 40 | 17 | 17 | 0 | 0.0 |
| Төрийн байгууллага | 4 | 1 | - | -1 | 0.0 |
| Аж ахуйн нэгж | 1 | 3 | 11 | 8 | 3.7[2] |
| Төрийн бус байгууллага | - | 3 | 5 | 2 | 66.7 |

Эх үүсвэр: Цагдаагийн газар

